



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 09 сарын 27 өдөр

Дугаар А/682

Булган сум

**Гүйцэтгэгчид гэрээ байгуулах
эрх олгох тухай**


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдааны 2023 оны 08 дугаар сарын 04-ны өдрийн XVII/01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Тоглоомын талбай байгуулах (Булган сум 2 дугаар баг) ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчээр шалгарсан “Арвин ган бумба” ХХК-тай 56,000,000 (тавин зургаан сая) төгрөгөөр гэрээ байгуулж, ажлын гүйцэтгэлд холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу хүлээлгэн өгөхийг “Ариун ган бумба” ХХК-ийн захирал (Х.Ганбаатар)-д үүрэг болгосугай.

3. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2023 оны
09 дугаар сарын 27-ны өдрийн
А/632 дугаар захирамжийн хавсралт



№	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1.	Алданги	Хоногт гүйцэтгээгүй үүргийн дүнгийн 0,1 хувь байна. Нийт алдангийн хэмжээ гэрээний үнийн дүнгийн 10 хувиас ихгүй байна.	Д.Батцогт
2.	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь	Ү.Бямбасүрэн